

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд тус зүйлд 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан М, онгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасан “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-нд хамаарна.

2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:

2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах харилцаа тул тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Төслийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тус төслийн Зээлийн хэлэлцээрийг хийж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэл, 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 05 дугаар захирамжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр гарын үсэг зурсан.

4. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:

Уг хуулийн төсөлд тусгасан Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газар хоорондын Зээлийн хэлэлцээрийн эх үүсвэрээр “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын багц ажил болон магадалшгүй бусад ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлэх бөгөөд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн зүгээс холбоотой бусад судалгааг хийсэн.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:

Хуулийн төсөлд 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын Зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасан “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-нд хамаарна. /“Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн санхүүжилтийн танилцуулгыг хавсаргав/.

*“Газрын тос боловсруулах үйлдвэр барих”
төслийн санхүүжилтийн талаар*

1. Зээлийн ерөнхий мэдээлэл

Зээлийн ерөнхий хэлэлцээр:

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улс (цаашид “БНЭУ” гэх)-ын Экспорт-Импорт (цаашид “ЭКСИМ” гэх) банк хоорондын 1.0 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийг 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан бөгөөд уг хэлэлцээрийг Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-ын чуулганы 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар соёрхон баталснаар хүчин төгөлдөр болсон.

Нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээр:

Монгол Улсын Засгийн газар болон БНЭУ-ын ЭКСИМ банк хоорондын 1.0 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлагдаж, төслийн хэрэгжилт эхэлсний дараа Төслийн удирдлагын зөвлөх болох “Инженерс Индиа Лимитед” компани техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийг боловсруулж, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн нийт зардалд 1,236.0 сая ам.доллартой тэнцэх санхүүжилт шаардлагатай гэж дүгнэсэн.

Үүний дагуу талууд 236.0 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээрийг 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, УИХ-аас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр соёрхон баталсан.

Зээлийн нөхцөл:

Зээлийн хугацаа:	20 жил
Зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	5 – 7 жил
Зээлийн хүү	1.75%
Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэлд тооцогдох жилийн шимтгэл	0.5%
Удирдлагын шимтгэл (нэг удаагийн)	0.5%
Төсөл хэрэгжиж дуусах хугацаа	2027 он

Эргэн төлөлтийн талаар:

БНЭУ-ын ЭКСИМ банктэй 2016 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу зээлийн анхны ашиглалт гарсан өдрөөс буюу 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс хойш 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, зээлийг нийт 20 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй. Үүний дагуу 1.0 тэрбум ам.долларын зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс эхэлж, жил бүр 64.5 сая ам.долларыг төлөх хуваарьтай байсан.

Гэвч үндсэн төлбөрийн эргэн төлөлт эхлэх хугацаа болох 2023 оны 2 дугаар сарын байдлаар **1.0 тэрбум ам.долларын зээлээс ердөө 112.0 сая ам.долларыг авч ашиглаад** байсан бөгөөд энэхүү зээлийн эргэн төлөлтийг эхлүүлэх нь улсын төсөвт дарамт үүсгэж, төлбөрийн хүндрэлтэй нөхцөл байдалд оруулахаар байсан тул Сангийн яамны зүгээс БНЭУ-ын ЭКСИМ банкинд эргэн төлөлтийн хуваарийг өөрчлөх

санал тавьж, эргэн төлөлтийг шийдвэрлэсэн 3 дэд зээлийн гэрээг байгуулах ажлыг Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Тус хуралдаанаар “Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хоорондын 1.0 тэрбум ам.долларын зээлийн эргэн төлөлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 259 дүгээр тогтоол гарсан бөгөөд тогтоолын хүрээнд 3 дэд зээлийн гэрээний хэлэлцээрийг 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр байгуулан жилд төлөгдөх зээлийн үндсэн төлбөр 64.5 сая ам.доллар байсныг 13.1 сая ам.доллар болгон бууруулж, EPC-02, EPC-03 багц ажлын зээлийн санхүүжилт болох 789.0 сая ам.долларын үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг дахин 7 жилээр сунгаж төсөвт ирэх дарамтыг бууруулаад байна.

2. Нэмэлт санхүүжилтийн шаардлагын талаар

Сүүлийн жилүүдэд үүссэн эдийн засгийн хямрал, бараа материал, техник, тоног төхөөрөмжийн үнийн өсөлт болон инженерчлэл, зураг төслийн үе шатанд үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, үйл ажиллагааны төвөгшил болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түгээлт, тээвэрлэлттэй холбоотой дэд бүтцийн өөрчлөлтүүд, мөн технологийн лиценз эзэмшигчдийн зүгээс тавьсан нэмэлт шаардлагуудтай холбоотойгоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн үнийн дүн 2018 онд боловсруулсан ТЭЗҮ-ээр тооцоолсон зардал болох 1,236.0 сая ам.доллараос 30 орчим хувиар өсөхөөр байгаа талаар “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-аас мэдэгдсэн.

Төслийн хөрөнгө оруулалтын зардлын өсөлтийг ТЭЗҮ-ийн тодотголд тусгасан бөгөөд тус тодотголыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (хуучнаар)-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, нийт төслийн зардлыг 1,698.2 сая.ам доллар байхаар хүлээн авсан. Иймд гэрээ байгуулсан нийт 1,236.0 сая ам.долларын зээлийн эх үүсвэрээс гадна 462.2 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх шаардлага үүссэн.

Мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтээр КОВИД-19 цар тахлын дараах тээвэр ложистик, бараа материалын үнийн өсөлт, байгууламжийн инженерчлэл, зураг төслийн үе шатанд үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, үйл ажиллагааны төвөгшил болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түгээлт, тээвэрлэлтийн дэд бүтцийг манай орны цаг уурын нөхцөлд тохируулах зэрэгтэй холбоотойгоор техникийн зарим нэмэлт, өөрчлөлт оруулах болсон зэрэг нь зардал өсөхөд нөлөөлсөн байна.

3. БНЭУ-ын талаас тавьсан нөхцөл

Төслийн нэмэлт санхүүжилтийг БНЭУ-ын ЭКСИМ банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хүсэлтийг Монгол Улсын Сангийн яамны зүгээс БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамаар дамжуулан БНЭУ-ын холбогдох байгууллагуудад 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлж, эх үүсвэрийг шийдвэрлэх талаар хамтран ажиллаж ирсэн. Монголын талаас нэмэлт санхүүжилтийн зээлийн хүсэлтийг хүргүүлж, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж ирсэн боловч БНЭУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд солигдсон, БНЭУ-ын Парламентын сонгууль, тухайн оны төсвийн төслийг боловсруулах зэрэг шалтгаануудын улмаас нэмэлт санхүүжилтийн шийдвэрлэлт удааширсан.

БНЭУ-ын Засгийн газраас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн нэмэлт санхүүжилтийг ЭКСИМ банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхийг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр зөвшөөрсөн бөгөөд дараах нөхцөлтэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг санхүүжүүлэх;
2. Зээлийн эх үүсвэр нь 1.75 хувийн хүүтэй, үйлчилгээний шимтгэл болон хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан шимтгэл тус бүр 0.5 хувь, 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 20 жил эргэн төлөгдөх нөхцөлтэй;
3. 2019 онд байгуулсан **236.0 сая ам.долларын Зээлийн хэлэлцээрийг** шинээр байгуулах зээлийн дүнтэй нэгтгэж нийт 700.0 сая ам.долларын Зээлийн хэлэлцээр байгуулах;
4. Зээлийн эх үүсвэрт туссан магадалшгүй зардлыг ашиглах тохиолдолд БНЭУ-ын ЭКСИМ банкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр ашиглах;
5. Үйлдвэрийн олох болон олсон бүх орлого, авлагыг Монгол Улсад орших аль нэг банканд нээсэн “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн дансаар дамжуулах бөгөөд хэрэв зээлийн гэрээний хүрээнд хүлээсэн үүргээ Засгийн газар биелүүлээгүй буюу зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн дансыг царцааж, төлбөрийг үйлдвэрийн орлогоос шууд татан авах;
6. Монгол Улсын Засгийн газар хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн аливаа төлбөрийн үүрэг дуусах хүртэл буюу 2045 он хүртэлх хугацаанд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн орлогод дарамт үүсгэх, үүсгэж болзошгүй аливаа асуудалд БНЭУ-ын ЭКСИМ банктэй зөвшилцөх;
7. Цаашид “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төсөлтэй холбоотой нэмэлт зардал гарвал Монгол Улсын Засгийн газар өөрийн төсвөөс бүрэн санхүүжүүлэх гэсэн нөхцөлүүдийг тавьсан.

Мөн Гаалийн тухай хуулийн **97.1**-д заасны дагуу төслийн хүрээнд ашиглагдах автотээврийн хэрэгсэл, машин механизм, техник, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийг гаалийн нутаг дэвсгэрт зөвхөн **1 жилээс дээшгүй** хугацаанд байршуулж байна. Энэ нь төслийн хэрэгжилтэд хүндрэл үүсгэж буй тул хэрэгжилтийг түргэсгэх үүднээс төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай импортоор орж ирсэн тоног төхөөрөмж, машин механизм, тээврийн хэрэгслийг **төсөл дуусах хүртэл** хугацаанд гаалийн түр горимд байршуулах зохицуулалтыг тус хэлэлцээрт тусгасан.

Зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаар яаралтай соёрхон баталж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэснээр “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх, үйлдвэр төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орох боломж бүрдэнэ. Иймд Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслийг Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх нөхцөл байдал үүсээд байна.